



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар A/354

Чингис хот

Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны 41, 43, 46, 51 дүгээр тушаал, Улсын Онцгой комиссын 24, 25 дугаар хурлын шийдвэр, аймгийн Шуурхай штабын удирдах бүрэлдэхүүний хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст халдвар (ковид-19)-ын батлагдсан тохиолдлын тархалтад хийсэн эрсдэлийн үнэлгээний дүгнэлтэд үндэслэн Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглож, хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ж.Эрдэнэбат), Цагдаагийн газар (хурандаа Б.Батсайхан), Мэргэжлийн хяналтын газар (Б.Сүнгээ), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт малын гоц халдварт шүлхий, хонины цэцэг өвчин голомтлон гарсантай холбогдуулан тархвар зүйн судалгааны эрсдэлийн үнэлгээгээр халдвар тархах нөхцөл “Магадлалтай өндөр” түвшинд үнэлэгдсэн тул хурдан морины уралдаан зохион байгуулахгүй байхыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлэх халдвар хамгааллын дэглэмийг мөрдүүлж хичээлийн шинэ жилийн бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Боловсрол, соёл урлагийн газар (С.Мөнхцэцэг), сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Аймгийн онцгой комиссын шуурхай штабын байнгын, тасралтгүй, шуурхай байдлыг хангуулан үүрэг гүйцэтгэх ажилтан, албан тушаалтны хариуцлагыг сайжруулж, холбогдох бүх мэргэжлийн байгууллагын жигд, тэнцвэртэй оролцоог хангуулж ажиллахыг Шуурхай штабын дарга, (хурандаа Ж.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

5. Аймгийн тандалт судалгааны багаас коронавируст халдвар (ковид-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан зөвлөмжийг хавсралтаар баталж, холбогдох

байгууллага иргэдэд хүргэх ажлыг зохион байгуулахыг Эрүүл мэндийн газар (Л.Мэндбаяр)-т даалгасугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав), Шуурхай штабын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ЦИДЭРБАТ



Аймгийн Засаг даргын 2021 оны  
07 дугаар сарын 18-и өдрийн A/354  
дугаар захирамжийн хавсралт

## АЙМАГ, СУМДЫН ОНЦГОЙ КОМИССТ

### Коронавирусын халдварт (COVID-19) цар тахлаас сэргийлэх, хариу арга хэмжээ авах зөвлөмж

-Өвчлөл гарсан айл, өрхийн иргэдийн 14 хоног, голомттой бүс нутгаас ирсэн иргэдийг 7 хоног гэрийн тусгаарлалтанд байх журмыг мөрдүүлэх

-Ойрын хавьтлуудын гэрийн тусгаарлалт тандалт хяналтыг АОК-ийн гишүүдэд хуваарь гаргасны дагуу холбогдох байгууллага, ажилчид онцгой анхаарч, үйл ажиллагаагаа сайжруулах

-Тусгаарлалтын дэглэм зөрчсөн иргэдэд зөрчлийн хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх, хариуцлага тооцсон тухайгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нээлттэй мэдээлэх

-Ойрын хавьтлуудыг гэртээ тусгаарлагдсан үед хүнс, эмийн сангийн хүргэлтийн үйлчилгээг зохион байгуулж, мобайл банкаар тооцоог хийлгэх

-Орон нутагт олныг хамарсан үйл ажиллагааг дэмжсэн тушаал шийдвэрүүд гаргахгүй байх

-Хот хоорондын хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах, ялангуяа Дэлүүн болдогийн пост болон Аймгийн орох хаалган дээрх хяналтыг сайжруулж, орж байгаа тээврийн хэрэгсэл болон иргэдийг нэг бүрчлэн бүртгэж, гарын үсгээр баталгаажуулан, мэдээллийг Хэрлэн сумын Шуурхай штаб, багууд болон Өрхийн эрүүл мэндийн төвд дамжуулах, тандалтыг хийлгэх

-Хэнтий аймаг руу нэвтэрч буй иргэн бүрийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг хэвээр үргэлжлүүлэх

-Замын хоолны газруудын эрүүл ахуйн байдалд тогтмол хяналт тавьж, аль болох нэг удаагийн хоолны хэрэгслүүдийг хэрэглэж хэвшүүлэх талаар шаардлага хургуулэх

### АЙМАГ, СУМДЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГУУДАД

- ЭМС-ын A/467 тоот тушаалын дагуу коронавирусын халдвараар батлагдсан тохиолдол бүрийг Аймаг, сумын хэмжээнд эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх, хавьтлын асуумж тодорхой, эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн болон түргэвчилсэн шинжилгээнд зэрэг байгаа тохиолдолд PCR шинжилгээний хариу хүлээлгүй, тусгаарлан авах арга хэмжээнүүдийг авч ажиллах

- Улаан бүсэд буюу ковидын эмчлэх эмнэлэгт ажиллаж байгаа ажилчдын халдварын сэргийлэлт хяналтанд анхаарах

- Эрүүл мэндийн байгууллагууд нь эмнэлгийн тусламж үйлчилгээний халдварын халдвар гаргахгүй ажиллах, халдвараас сэргийлэх хяналтыг сайжруулах ба ажилчдын хүн хоорондын зайд барьж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх

- Эрүүл мэндийн байгууллагууд эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын нөөцийн бэлэн байдлыг хангаж ажиллах, тусламж үйлчилгээг доголдуулахгүй байх

- Эрсдэлт бүлгийн /0-5 насны хүүхэдтэй, жирэмсэн, өндөр настай, архаг хууч өвчтэй, хүнд өвчтэй/ хүн амын судалгааг гаргаж, эрүүл мэндийн байдал болон тухайн айл өрхөөр орж гарч байгаа хүмүүсийн хөдөлгөөний тандалтыг сайжруулах

- ЭМС-ын 2021 оны 07 сарын 18-ны өдрийн A/467 тоот тушаалын дагуу эмнэлгээс гарсны дараах хяналтыг сайжруулах

- Эмнэлгийн аюултай хог хаягдлыг ЭМС-ын 505 тоот тушаалын дагуу ангилах, устгах үйл ажиллагааг чанд мөрдөх

- Нас баралт гарсан тохиолдолд ЭМС-ын A/214 тоот тушаалыг мөрдөх

- Мэргэжлийн эмч нараас ковидын тандалт сэргийлэлтийн чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө авах
- Коронавирусын эсрэг дархлаажуулалтанд хамрагдаагүй иргэд, хүүхдүүдийн судалгааг нягтлан гаргаж, дархлаажуулалтанд хамруулах
- Нийт айл өрх /ялангуяа өвчлөл бүртгэгдсэн айл өрх/, албан байгууллагад өдөр тутам цэвэрлэгээ, халдвартгүйтгэлийг сайжруулах арга зүйн зөвлөмж өгөх
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр “Дельта вирус”-ийн талаарх үнэн зөв мэдээллийг хүргэж, урьдчилан сэргийлэх аргуудыг хувь хүн бүр ухамсартайгаар туштай хэрэгжүүлэхэд байгууллагын удирдлага хяналт тавьж ажиллах

## **ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДАД**

- Нийт албан байгууллагууд ажилчдын халдварт өртөлтийг илрүүлэх хяналтыг улам эрчимжүүлж, туштай мөрдөж ажиллах/өглөө оройны халуун хэмжих, амны хаалтны бүрэн зөв, тогтмол хэрэглээ, гарсаа халдвартгүйжүүлж байгаа байдал г.м/
- Ойрын хавьталь болсон ажилчдыг тусгаарлах журмын дагуу тусгаарлаж, хяналтын хугацаа дууссан тохиолдолд ажилд нь оруулах
- Хүн хоорондын зайлбарыг барьж ажиллах нөхцөлийг бүрдүүлэх
- Үдийн цай, хооллоптыг олноор нэг дор бөөгнөрч идэхийг хориглох
- Байгууллагын агаар сэлгэлт, цэвэрлэгээ, халдвартгүйтгэлд онцгой анхаарч, цэвэрлэгч, үйлчлэгч нарын ажлын гүйцэтгэлийг сайжруулах/ цэвэрлэгээнд халдвартгүйтгэлийн бодисыг зөв тогтмол хэрэглүүлэх
- Албан томилолтоор халдвартын голомттой бус нутагт томилогдон ажилласан ажилчдыг томилолтоос буцаж ирэхэд тусгаарлагдах журмын дагуу 7 хоног тусгаарлаж, тусгаарлалтын хугацаа дуусмагц түргэвчилсэн шинжилгээнд хамруулж ажилд нь оруулж байх
- Албан байгууллагуудад өвчлөл бүртгэгдэж голомтлон гарах эрсдэл үүссэн тохиолдолд цаг алдалгүй Тандалтын баг очиж ажиллан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх

## **АЙЛ ӨРХҮҮДЭД**

- Айл өрхийн гишүүн бүр гаднаас гэртээ орж ирэхдээ гар халдвартгүйжүүлэгч тогтмол хэрэглэх, гарсаа тогтмол савандаж угааж хэвших
- Эцэг эхчүүд хүүхэд бүрт халдвараас урьдчилан сэргийлэх байдалт хяналт тавьж хэвших
- Олон хүн гар хүрдэг талбай болон хаалганы бариул, унтраалга, зурагтын удирдлага, гар утас зэргийг тогтмол халдвартгүйжүүлж байх
- Гэр орондоо зочин урихгүй, айлд зочлохгүй байх талаар хүн бүр бүрэн ухамсарлаж, хэрэгжүүлэх
- Орчны цэвэрлэгээ ариутгал, хог хаягдлын байдалд айл бүр хяналт тавьж, шаардлагатай үед хариуцсан СӨХ-дөө шаардлага тавьж байх
- Ойрын хавьтлын тусгаарлалтын байдалд хөршийн хяналтыг сайжруулж, зөрчил гарсан тохиолдолд шударгаар мэдээлэх
- “Ковид-19” халдвартын сэжигтэй шинж илэрвэл өрхийн эмнэлэгт яаралтай утсаар хандах